



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 02 дугаар сарын 05 өдөр Дугаар 14

Хэрлэн сум

XIV ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 14 дүгээр хуралдаан 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 16:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 84,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1. Жудо бөхийн "Ялалт" клуб, "Хэрлэн номин бизнес төв"-ийн дэргэдэх спорт заал, "Талын хүлэг" авто жолооны сургалтын төвийн үйл ажиллагааг нээх эсэх талаар танилцуулах,

Эрүүл мэндийн газар

2. Сүм, хийдэд хяналт, үнэлгээ хийсэн тухай танилцуулах,

Эрүүл мэндийн газар

3. Сар шинийн баяр болохтой холбогдуулан халдвараас урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай аймгийн Онцгой комиссын тогтоолын төсөл танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

4. "Хан цайз" ХХК, "Анчэс буйр" ХХК-уудтай хамтран ажиллах гэрээг танилцуулах,

Авто тээврийн төв

5. Дотоод хяналт, шалгалтын ажлын хэсэг Хөлөнбуйр сумын шалган нэвтрүүлэх хяналтын цэгт ажилласан тухай танилцуулах,

Тагнуулын газар

6. Сумдын ерөнхий боловсролын сургуулиудын спорт заалыг нээх эсэх талаар хэлэлцэх,



Эрүүл мэндийн газар

7. Аймгийн Онцгой комисст иргэд, аж ахуй нэгж байгууллагуудаас ирүүлсэн хүсэлт, албан бичгийг танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

8. Бүртгэл, хяналтын системийн явцын талаар танилцуулах,

Статистикийн хэлтэс

/  / М.Бадамсүрэн
/  / Э.Ганжигүүр

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа нарт:

1.1."Хэрлэн номин бизнес төв"-ийн дэргэдэх спорт заалны үйл ажиллагааг танхимд 20-оос дээшгүй хүнтэйгээр халдвар хамгааллын дэглэмийг баримтлан эхлүүлэхийг зөвшөөрөв,

1.2."Талын хүлэг" авто жолооны сургалтын төвийн үйл ажиллагааг танхимд 8-аас илүүгүй хүнтэйгээр халдвар хамгааллын дэглэмийг баримтлан эхлүүлэхийг зөвшөөрөв,

1.3.Жудо бөхийн "Ялалт" клубын үйл ажиллагааг танхимд 8-аас илүүгүй хүнтэйгээр халдвар хамгааллын дэглэмийг баримтлан эхлүүлэхийг зөвшөөрөв,

Хоёр.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа-д:

2.1.Аймгийн ерөнхий тархвар судлаач эмчийн зөвлөмжийг хавсарган албан бичгийн хамт Данриг Даржаалин, Түвдэн Даржэйлин, Үржин чойлон хийдүүдэд чиглэл хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа нарт:

2.2.Сүм, хийдийн ширээг хооронд нь 2,0 метрийн зайтай байрлуулах, шаардлагатай тохиолдолд ашиглах тусгаарлах өрөөг тохижуулж бэлтгэх, агаар сэлгэлт, гар ариутгал, бүртгэлжүүлэлт хийх талаар чиглэл өгч бэлтгэл ажлыг хангуулахыг,

2.3.Сүм, хийдийн хамба ламуудтай уулзалт зохион байгуулахыг,

2.4.Сар шинийн баярын өдрүүдэд сүм, хийдийн халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж ажиллах талаар санал боловсруулж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулахыг,

Хэрлэн сүмн Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч,
Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир:



2.5.Данриг Даржаалин, Түвдэн Даржэйлин, Үржин чойлон хийдүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг,

Гурав.Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын
гишүүн Ц.Мөнхтөр-д:

3.1."Хан цайз" ХХК, "Анчэс буйр" ХХК-уудтай хамтран ажиллах гэрээ байгуулахыг зөвшөөрөв,

3.2."Хан цайз" ХХК, "Анчэс буйр" ХХК-ийн ачаа тээврийн үйл ажиллагаа, халдвар хамгааллын дэглэмд хяналт тавьж ажиллахыг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын

/  / М.Бадамсүрэн
/  / Э.Ганжигүүр

орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа нарт:

3.3.Карго ачаа тээврийн үйлчилгээ эрхэлдэг зөвшөөрөгдсөн байгууллагуудтай халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хариуцлагын гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг,

Дөрөв.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

4.1.Сар шинийн баяр болохтой холбогдуулан халдвараас урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай аймгийн Онцгой комиссын тогтоол боловсруулж батлуулахыг,

Тав.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

5.1.Хөлөнбуйр сумын шалган нэвтрүүлэх хяналтын цэгийн хяналтын камерыг яриа бичигчтэй камераар сольж байршуулахыг,

5.2.Зочид буудлуудад бүртгэл, хяналтыг сайжруулах чиглэлээр албан бичиг хүргүүлэхийг,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа нар:



5.3.Чойбалсан хот, Хөлөнбуйр, Булган, Баянтүмэн сумдаар нэвтрэн өнгөрөх уул уурхайн компанийн тэсрэх бодис тээвэрлэлтийг Цагдаагийн байгууллагын хамгаалалттайгаар нэвтрүүлэх талаар Шалган нэвтрүүлэх хяналтын цэгийн ахлагч нарт чиглэл хүргүүлэхийг,

Зургаа.Сумын Засаг дарга нарт:

6.1.Сумдын ерөнхий боловсролын сургуулиудын спорт заалны агааржуулалтыг сайжруулах, халдвар хамгааллын дэглэм мөрдүүлэх, дараагийн тусгаарлах байрны бэлэн байдлыг хангасан тохиолдолд сумын Онцгой комиссын шийдвэрээр спорт заалны үйл ажиллагааг эхлүүлэхийг зөвшөөрөв,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа-д:

6.2.Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр гарсан хууль, тогтоомжийг хэрэгжүүлээгүй аж, ахуйн нэгж байгууллагуудад хууль, тогтоомжийн дагуу зохих арга хэмжээ авч ажиллах талаар мэдэгдэхийг,

 / М.Бадамсүрэн
 / С.Ганжигүүр

Долоо Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа нарт:

7.1.Уул уурхайн ээлж солих ажилчдыг Чойбалсан хотод бэлтгэсэн зочид буудалд 7 хоног тусгаарлаж, шинжилгээний хариу сөрөг гарсан тохиолдолд ажлын байранд бэлтгэсэн тусгаарлах байранд бусадтай хавьтал болголгүй 7 хоног тусгаарласны дараа ажилд нь гаргахыг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дарга,
Онцгой комиссын гишүүн Д.Должин нарт:

7.2.Шаардлагатай уул уурхайн компаниудад холбогдох албан хаагчдыг томилон хяналт тавьж ажиллуулахыг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

7.3.Шалган нэвтрүүлэх хяналтын цэгт ашиглах 15 ширхэг дардас, тэмдгийг хийлгэхэд шаардагдах 1,020,000 төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэхийг,

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзий-д:

7.5.Шалган нэвтрүүлэх хяналтын цэгийн дардас, тэмдэг ашиглах журам боловсруулж батлуулахыг,



Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа-д:

7.6.Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын лабораторит шинжилгээнд явуулсан халдваргүйтгэлийн бодист шинжилгээ хийлгэхэд гарсан 83,000 төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэхийг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

7.7.Хөлөнбуйр сумын шалган нэвтрүүлэх хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж буй албан хаагчдад шаардлагатай халдвар хамгааллын хувцас 160 ширхэг, нэг удаагийн N95 амны хаалт 68 ширхэг, сүү 108 ширхэгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас олгохыг,

Найм Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын

/  / М.Бадамсүрэн
/  / Т.Ганжигүүр

гишүүн Д.Мөнхтуяа,
Тагнуулын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Б.Бямбаа нарт:

8.1.Бүртгэл, хяналтын систем ашиглах албан хаагчаар нууцын баталгаа гаргуулахыг,

АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ-д:

8.2.Бүртгэл хяналтын систем ашиглах журам боловсруулж батлуулахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА М.БАДАМСҮРЭН



БҮСИЙН ТӨВ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ДЭД ДАРГА, ДЭД ХУРАНДАА Б.БАТТУЛГА